

**МОНГОЛЫН ОЛОНХГҮЙ ПАРЛАМЕНТЫГ СУДЛАХ  
ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛД**

Ж. ТӨРТОГТОХ

*Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс Төр Судлалын Тэнхим*

**ЦАЛТАНСҮХ**

*Магистрант, Улс Төр Менежментийн Академийн багш*

**Түлхүүр үг:** Hung parliament, Хаан сонголт, Олонхгүй парламент, Олон улсын жишиг, Хууль эрх зүйн зохицуулалт

**Товч утга:** Манай улс Парламентын засаглалыг төлөвшүүлэн өдгөө зургаан сонгуулийн үр дүнд засгийн газраатайван. үндсэн хуулийн дагуу өөрчлен сольж ирлээ. Сонгуулийн үр дүнд бий болох олонх нь засгийн газраа байгуулдаг Вестминстер загвартай улс орнуудад парламентын сонгуул аль нэг намыг олонх болгохгүй байх тохиолдол дэлхий нийтэд байдаг. Энэ тохиолдол манай улсын хувьд хоёр дахь удаагаа тохиож байгаа нь энэ цаг үе болоод байна. Ийм тохиолдолтой тулгарсан аль ч орны хувьд Засгийн газрыг байгуулах, тогтвортой, үр өгөөжтэй бодлого зэрэг нь анхаарлын төвд орж байна.

Манай энэ удаагийн олонхгүй парламентыг сонгуулийн системийн өөрчлөлттэй холбож болох ч мөн улс төрийн намуудын иргэдээс хүлээх дэмжилг буурсан, иргэд улс төрийн нам цаашаад улс төрд итгэх алдартсан гэх олон үндэслэл бүхий таамаг бас байна. Эдгээрээс үзэхэд манайд олонхгүй парламент тохиох давтамж олшрон ойртох зүй тогтол байхыг үүгээсгэж болохгүй юм. Иймд олонхгүй парламент, түүний үүсэх боломжит нөхцөлийг дурдан дэлхийн улс орнуудад үссэн тохиолдол зохицуулсан жишигийг харгалзан үзэж өөрийн орны хувьд тогтолцооны сүл тал, орчин үеийн улс төрийн институцын хөгжил, эрэлтэд нийцүүлэн боловсронгуй болгох боломжийг арга зүйн хувьд авч үзсэн болно.

**Abstract:** Parliament authority has been developed in Mongolia for 6 years as well as it has been changed in peaceful way by the constitution. In some countries those specific political modeled such as Westminster it happens that usually the party which won the most majority of the vote got power in the parliament. In order to other parties would not able to have much rights in the parliament. This kind of case has been occurred twice in Mongolia. For that case it's important to have a proper political conception to establish a new government.

The result of today's less majority of parliament is caused of the vote change as well as support trust, or belief from public has been dropped for political parties.

There for it looks like Mongolian parliament with less majority vote there is high rate of reputation of more often. This paper studies the experiences of growth and recovery of other countries on the similar situations that has less majority vote parliament and also the weak side and development of political institutions has been showed by the compared results.

\*\*\*\*\*

**Үдиртгал**

Монголчууд бил Ардчилсан үндсэн хуулиа баталсанаас өдгөө нэгэнт 20 жилийг хол туулсан байна. Дэлхий нийтийн туршлагаас үзэх аваас ардчилсан төрийн тогтолцоо байгууламжийг буй болгож тогтвортжуулахад ихэнх улс үндэстэн ойролцоогоор 20 орчим жилийг зарцуулж байжээ<sup>1</sup>. Ингэж үзвэл Монголын ардчилал эрийн цээнд нэгэнт хүрсэн гэж үзэж болох юм. Бидний замнаж буй Ардчилал Монголын түүхэнд анх удаа тохиож буй үйл явц уу, өмнө нь хэзээ нэгэн цагт тохиож өдгөө давтагдаж буй хэрэг үү гэсэн асуултад хариу өгөх нь ардчиллын талаарх бидний уламжлал, туршлагыг харуулах ач холбогдолтой байж болох юм. Энэ тохиолдолд ХХ зууны эхэн үеийн Үндэсний ардчилсан үзэл санаа, өрнөлийг үндэс болгон Монгол орныг ардчиллын туршлагатай орон, “ардчиллыг сэргээн тогтоож буй орон”<sup>2</sup> гэж үзэж болдог байна. Хэрэв ардчилал нэгэнт тогтсон бол түүнийг хэрхэн тогтоож барих бататгах нь аль ч орны өмнө тулгарах нь тодорхой<sup>3</sup> аж. Өнгөрсөн зуунд алдсан Ардчиллыг ирээдүйд

<sup>1</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын ардчиллын төлөвшил” УБ 2011 он 60 ху үз

<sup>2</sup> “Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын V бага хурал, МУ-ын Ерөнхий сайд Н. Энхбаярын илтгэл УБ 2003 он

<sup>3</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын ардчиллын төлөвшил” УБ 2011 он 16ху үз

бэхжүүлэх, бататгахын тулд бил нэгэнт анхаарал тавих хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Мэргэжлийн судалгааны байгууллагуудын, Монголын арчилалд шилжих үйл явц 1990-ээд оны дунд үе хүртэл харьцангуй сайн үр дүнтэй байж байгаад 90-ээд оны 2-р хагасаас хүсүүшгүй үр дагавар нь ихсэж, 2000 оноос хойш бүр зогсолт, ухралтууд гарах болж байгаа гэсэн дүгнэлтэд үндэслэн манай толгой эрдэмтэд үүнд яагаад ингэвэ? цаашид яах? гэх зэрэгт шинжлэх ухааны үүднээс тодорхой хариулт егөх ёстойг сануулан бичиж байна<sup>4</sup>.

Ямартай ч болов арчиллын ирээдүйт үрчилан хэлэхэд хэцүү бөгөөд арчилал тийм ч амархан хэрэгжүүлдэг эд биш. Арчиллын ирээдүй бүдэг байна<sup>5</sup>. Мартин Сланин Аарчиллын гуравдахъ давалгааны үр дүнд арчилагдсан орнуудын арчилалд өгсөн “арчилал ухралтад орохгүй гэсэн баталгаа байхгүй байна”<sup>6</sup> гэсэн нийтлэг дүгнэлт ч бидэнд хамаараа болохыг санаад илүүдэхгүй юм.

Арчилал яагаад хэрэгтэй вэ? Гэдгийг тодруулах Аарчиллын давуу талууд<sup>7</sup> Монгол улсыг маань туштай энэ замналаараа замнаад хүргэх нь зайлшгүй юм. Ингээд бид арчилсан институтыг бэхжүүлж улмаар ирээдүйд өртөж болзошгүй тэдний дарамт шахалтуудыг эсрэг сөрөн зогсоход чиглэсэн арга хэмжээ авах нь зүйтэй<sup>8</sup>. Манай УИХ ба Засгийн газрын хоорондын харилцаанд янз бүрээр тайлбарлаж болох ойлгомжгүй байдлууд үргэлжилсээр байна<sup>9</sup>. Өнөөдөр энэ байдлын нэгээхэн хэсэг бөгөөд өдгөө бөгөөд цаашид дагуулж болох үр дагавар ихээрээ ач холбогдоо өргөсөн тулгамдсан асуудал, бэрхшээл бол олонхгүй парламентын нөхцөл байдал болж байна.

#### *Олонхгүй парламент гэж чадаа?*

Парламенттад ёс нь төрийн тогтолцоо, эрх мэдэлд ард түмний хүсэл зориг илэрхийлэгдэж байх, ард түмнээс сонгогдсон төлөөлөгчдийн байгууллага нийтээр дагаж мөрдөх хуулийг тогтоож байх ёс юм. Ийнхүү төрийн төлөөлөгчдийн байгууллагын албан тушаалтаныг сонгодог болсоноор тухайн улсын төр засагт ард түмний төлөөлөл, оролшоо хяналт бий болон, төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй байх тухай үзэл санаа бодит зүйл болон хувирах нөхцөл бүрэлдэв<sup>10</sup>. Энэхүү парламенттад ёсны илэрхийлэл болсон, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн төлөөлөгчдийн дээд байгууллага нь парламент юм.

Дэлхий дээр парламент буюу хууль тогтоох байгууллагыг үндэсн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн улс орон дийлтэнх ихэнх юм. Парламентыг төлөөллийн байгууллага болох төрөлхийн шинжийг нь ашиглан олон арчилсан бус дэглэмт улс орон хэлбэр төдий ч болов байгуулсан байна.

Эдгээр улс орны Парламентад нэг нам эвсэл холбоо дангаар олонх болоогүй тохиолдол олон ч, энэ нь гагшүү үүтгэж буй асуудал, дагуулах үр дагавар, зайлшгүй шийдвэрлэх хэрэгшээгээрээ Парламентын засаглалтай улс оронд түлхүү анхаарлын төвд тавигдаж байна. Өөроөр хэлбэл парламентаасаа засгийн газараа байгуулдаг улс төрийн тогтолцоо, эрхзүйн зохицуулалттай улс оронд энэ нь улс төрийн томоохон асуудал, тогтвортгүй байдлыг дагуулж байна. Ийм ч учраас парламентын засаглалын сонгодог жишиг Англид энэ тохиолдолд /олонхгүй парламент үүссэн нөхцөлд/ улс төрийн хямралаас сэргийлэх, бодлогын үр ашигтай байдал, төр засгийн тогтвортой байдал, үр өгөөжийг судлан дээшлүүлэх зорилготой судалгааны байгууллага ажилладаг байна<sup>11</sup>.

Парламентын засаглалд. ямар нэг улстөрийн нам (эсвэл эвсэл холбоо) парламент буюу хууль тогтоох байгууллагад дийлтэнх олонх болоогүй тохиолдолд парламентыг Hung parliament гэж нэрлэдэг<sup>12</sup>. Энэ ойлголтыг манай улсад “олонхгүй парламент” хэмээн орчуулан ойлгож байна. Иргэд олон нийт “хаан сонголт” хэмээн нэрийдэх нь ч бий.

“Олонхгүй парламент” гэх ойлголтыг шууд “Эвслийн Засгийн газар” хэмээн холбон ойлгох ойлголт манайд цөөнгүй байх бөгөөд төдий оновчгүй юм. Тодруулбал парламентад олонх байсан ч эвслийн засгийн газар байгуулагдсан жишиээ дэлхийн зарим орнуудад, тухайллан манайд ч бий юм. Энэ нь олонхгүй парламентын үр дүнд үүссэн Засгийн газрыг нэрлэх оролдлого бололтой юм. Хэрвээ ийн нэрийдэхэд хүрвэл энд Канадын “Цөөнхийн Засгийн газар” гэх ойлголт нь логик ойлголтоор шууд бүрэн давхсан ойлгогдож байна.

<sup>4</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын нийгмийн бөрчлөлт” УБ 2013 он 232 ху үз

<sup>5</sup> Мартин Сланин “Улс төрийн удиртгат” УБ 2007 он 112 ху үз

<sup>6</sup> Мөн тэнд 116 ху үз

<sup>7</sup> Роберт Даиль “Арчиллын тухай” орчуулсан Ч. Энхбат, Д. Ганхуяг

<sup>8</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын арчиллын төлөвшүү” УБ 2011 он 16 ху үз

<sup>9</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын нийгмийн бөрчлөлт” УБ 2013 он 243 ху үз

<sup>10</sup> УИХ, ТГ “Дэлхийн улс орнуудын парламент” УБ 2010 он 24 ху үз

<sup>11</sup> //http://www.instituteforgovernment.org.uk үз

<sup>12</sup> Hung parliament – http://en... Hung parliament үз

“Олонхгүй парламент” нь үүсэх боломжийн хувьд Пропорциональ, Холимог сонгуулийн системийг ашигласан нөхцөлд илүү өндөр бөгөөд энэ талаараа олон намын тогтолцоотой улс оронд элбэг тохиолдох нь бий. “Олонхгүй парламент”-ын тухайд сонгуулийн систем, намын системтэй холбон үзэх нь зайлшгүй бөгөөд энэ талаар дэлхий нийтэд дараах үзэл тогтижээ. Тухайлбал пропорциональ төлөөллөөр сонгогдох хууль тогтоох байгууллагатай мөн олон намын системийн үед, нийт суудлын дийлэнх олонхыг авсан ялагч нам ховор тохиолдох бөгөөд иймд “Hung parliament” нь тогтсон хэм хэмжээ, хэвшил болсон байдал<sup>13</sup>.

Хоёр намын системтэй үед бүх нийтийн сонгуулийн үр дүнд нэг нам дийлэнх олонх болж улмаар шинэ засгийн газрыг маш хурдан байгуулагдах боломж өндөр байна. Энэ тохиолдолд “Hung parliament” үүсэх нь онцгой гаж тохиолдол бөгөөд магадгүй нарийн тооцоолсон хэрэг байж болох юм<sup>14</sup>.

Хэрвээ хууль тогтоох байгууллага нь хоёр танхимтай бөгөөд засгийн газар нь зөвхөн доод танхимины өмнө хариуцлага хүлээдэг бол “Hung parliament” нь зөвхөн энэ тэнхимтэй холбоотойгоор хэрэглэгдэнэ<sup>15</sup>. Дээр өгүүлсэнчлэн “Олонхгүй парламент” нь Парламентаас гүйцэтгэх эрх мэдлийг “төрүүлдэг” тохиолдолд асуудал дагуулдагийн хувиар энэ тохиолдлын хамгийн эзэгтэй, сонирхолтой үйл яви нь Засгийн газрын бүрдэл, томилгоо байдаг юм. Hung parliament -ын үед нэг бол аль аль гол намууд жижиг гуравдагч этгээдтэй хамтран эвслийн засгийн газар байгуулахыг эрмэлзэх, нөгөөтэйгүүр бие даагчид болон гуравдагч хүчинээс өөрийг нь дэмжинэ гэсэн хүчиний итгэлд түлгүүрласан, бусад хүчиний дэмжлэгэнд сууриссан цөөнхийн засгийн газар үүсч болох юм. Хэрэв эдгээр хүчин чармайлт нь амжилтгүй болсон бол, Парламентыг тарааж улмаар эцсийн найдвар гарц нь шинэ сонгууль болж хоцордог<sup>16</sup>.

Берлиний улс тэр судлаач Херфрийд Мюнклер даяарчлалын нөхцөл дэх парламентын ардчиллын нэг томоохон асуудлыг анхааруулан заасан байна. Тэрээр өдгөөг хүргэлх парламентын ардчиллын гол давуу тал юу байв? Парламентын ардчилал шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж, ардчилсан зөвшилцөөнийн баталгаажуулж, буруу шийдвэр гаргах явдлыг хумисан гэжээ<sup>17</sup>. Өнөөдөр “Олонхгүй парламент”-ын томоохон үр дагаварын нэг нь ялимгүй олонхын холбоонд дулдуудсан аливаа шийдлүүд цаашид дээр өгүүлсэн парламентын ардчиллын үндсэн давуу талыг үнэгүйдэлэхэд хүргэж болохоор байна.

Дээрхээс нэгтгэн үзэхэд олонхгүй парламент гэх ойлголт нь иргэдийн сонгосон төлөөллийн байгууллагаас засгийн газараа байгуулдаг улс оронд ихээхэн чухлаар тавигдах нь тодорхой байна. Онцлон өгүүлэхэд парламент дахь олонх бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэн засаглалын нөөц эрх мэдлийг эзэмшин хэрэгжүүлэх “олонхын ардчилал”-ын гол амин сүнс нь иргэдийн төлөөллөө сонгох сонгуулийн үр дүнд бий болсон төлөөллийн байгууллага дахь олонхыг иргэд нийтийн дийлэнхийн хүсэл сонирхол гэж үздэгт оршино. Иймд олонхгүй парламент бол засаглах эрх мэдлийг аль нэгэн улс төрийн намд олгоогүй иргэд нийтийн хүсэл сонирхол мөн ажээ.

Энэхүү засаглах, бодлого мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх эрх мэдэл, зөвшөөрлийг иргэд аль нэг намд олгоогүй тохиолдолд яах вэ? гэдэг асуудал олонхгүй парламентыг судлах цаашдын гол асуудал болж байна.

#### **“Олонхгүй парламент”-ын олон улс дахь туршлага, жишиг**

Олонхгүй парламент Англи, Австрали, Швейц, Канад, Итали, Грек зэрэг орнуудад хэд хэдэн удаа тохиолдож байсан байдаг.

Канадын хувьд сүүлийн 3 парламент (38, 39, 40) олонхгүй байсан бөгөөд тэд ийм нөхцөл байдлыг “hung parliament” гэж нэрлэдэггүй, харин “Цөөнхийн засгийн газар”, “Цөөнхийн парламент” гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл хуульд заасан олонхийн шалгуурыг давсан суудал бүхий нам байхгүй л бол бүгд цөөнхийн статуст орж байгаа хэрэг<sup>18</sup>.

Швед улсын хууль тогтоох байгууллагын өнгөрсөн бүтцэд аль ч нам парламентын олонх болж чадаагүй. Тэд ийм нөхцөлөөс гарахдаа парламент дахь хамгийн олон суудал бүхий намаа серөг хүчин болгосон буюу түүнээс доогуур суудалтай намууд нь зөвшилцөн эвслийн засгийн газар байгуулжээ. Одоо ч Шведийн парламент олонхгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт сонгогчдын 37,9

<sup>13</sup> Hung parliament – <http://en.wikipedia.org/> Hung parliament үз

<sup>14</sup> Hung parliament – <http://en.wikipedia.org/> Hung parliament үз

<sup>15</sup> Hung parliament – <http://en.wikipedia.org/> Hung parliament үз

<sup>16</sup> Hung parliament – <http://en.wikipedia.org/> Hung parliament үз

<sup>17</sup> Удо Б. Баркманн “Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллиүүд” ном 2012 оны өгүүлэл

<sup>18</sup> En.wikipedia.org- lastest hung parliament үз

хувийн санал авсан Социаль демократ нам болон Ногоон намын эвсэл Засгийн газраа байгуулсан байна<sup>19</sup>. Ийнхүү Шведэд цөөнхийн Засгийн газар ажиллаж байна.

Англид 1929 оны сонгууль анхны “Hung parliament”-ыг нехцелдүүлсэн юм. Үүнээс хойш бараг хагас зуун жилийн дараа буюу 1974 оны сонгуулиар нийтийн танхимд олонх тодорсонгуй. Уг сонгуулиар өмнөх Ерөнхий сайд Эдуард Гэйтын нам хамгийн олон суудалтай болсон боловч бусад жижиг намуудын итгэл дэмжлэгийн үр дүнд Харолд Уилсоны Хөдөлмөрийн нам цөөнхийн засгийн газар байгуулж ажиллав. 2010 оны Английн сонгууль төлөөлөгчидийн танхимд мөн л олонхийг гаргаж ирээгүй бөгөөд өдгөө эвслийн Засгийн газар байгуулагдан ажиллаж байна<sup>20</sup>.

Австралийн парламент Вестминстерийн загварыг хуулбарласан байдаг. Тэд “hung parliament”-ыг парламентын доод танхимд Australian Labor Party, Liberal National coalition хоёрын аль нэг нь олонх болж чадахгүй байгаагаар ихэнхдээ ойлгодог. “Hung parliament” Австралийн холбооны түвшинд ховор тохиох бөгөөд үнэндээ энэ нь хоёр намын системтэй нь холбоотой юм.

Ийнхүү 1910 он, 2 намын систем Австралид бэхжээд байсан боловч “Hung parliament” хоёр удаа тохиосон байна. Эхнийх нь 1940 онд тохиосон бөгөөд Роберт Мензис бие даагчдаар дэмжүүлж Ерөнхий сайдаар томилогдсон ч 1941 онд бие даагчид нь Хөдөлмөрийн намыг дэмжсэнээр Жонн Картини засгийн газараар солигдсон байна.

Хоёрдахь нь 2010 оны холбооны сонгуулиар хоёр гол хүчин тэнцүү (72:72) суудал авсанаар тохиолддээ. Жулия Гиллард бие даагчид болон Ногоон намын дэмжлэгтэйгээр өөрийн засгийн газараа эмхлэн байгуулж чаджээ.

Австралид сонгуулийн дараа бий болоод байгаа иймэрхүү тодорхойгүй нехцэл байдалд харьцангуй олон суудалтай намын лидерүүд “зохиомол олонх” бүрдүүлэхийн тулд бие даагчид эсвэл цөөн суудалтай жижиг намуудтай хэлэлцэх нь ёс мэт болжээ<sup>21</sup>.

Грекийн 2012 оны сонгуулийн үр дүн хууль тогтоох байгууллагад олонхийг бүрдүүлэснгүй. Энэ үеийн Грекийн улс төр, эдийн засгийн байдал тогтвортгүй байсаны гол буруутнуудыг иргэд улстөрийн намын удирдлагуудтай холбон үзэж байсантай олонх тодроогүйг холбож ойлгож болно. Грекийн Социалист хөдөлгөөний нам эвслийн засгийн газар байгуулахыг оролдсон ч бүтэлгүйтсэн бөгөөд тэдний хувьд шинэ сонгууль л гары болсон юм<sup>22</sup>.

Hung parliament-ын нехцэл байдалд гадны орнуудын олсон шийдэл гарц ихэвчтэн олонх болох хэмжээний аль нэг улс төрийн хүчинтэй эвсэх эвслийн засгийн газар байгуулах жишигтэй байгаа бөгөөд үүнд улс төрийн системийн онцлог, тухайн улс бүрийн биесээсээ үлгэрлэн хуулбарлах байдал нелөөлсөн байх магадлал бий юм.

Нийтлэг түгсэн олонх болох хэмжээнд эвсэх шийдэл гарцуудыг дэлхий нийтэд судлаачид Хамгийн багаар мажоритар болох эвсэл (Minimal winning coalition), Минимум хэмжээ гэх мэт тохиролцооны зарчмуудал дурдсан байдаг. Эдгээр нэршил аль аль нь эвсэлд илүү байр сууринаас оролцох боломжтой нам хүчиний тухайн кабинетэд өөрийн эрхийн төвлөрөлийг нэмэгдүүлж, засаглалын нөөцийг хуваалиах талуудыг багасгах зэрэг улс төрийн ашиг сонирхолтой нь холбогдож тайлбарлагдаж сайшаагддагаас бус тогтвортой, төрийн бодлогын чадамж зэргээр төдий сайн үнэлээгүйг шохон тэмдэглэх нь зүйтэй юм.

#### *Монгол дахь олонхгүй парламент*

Манай орны хувьд “Олонхгүй парламент” –гэсэн ойлголттой уялдуулан УИХ дахь “олонх”, “цөөнх”-ийг тодорхойлсон хуулийн томъёоллыг юуны өмнө дурдах нь зүйтэй юм. УИХ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнхийг тодорхойлсон байна. УИХ-ын тухай хуулийн 8.1-д Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлгийг Улсын Их Хурал дахь олонхи (цаашид “олонхи” гэх) гэнэ. 8.2-д Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвслийн бүлэг, гишүүнийг цөөнх (цаашид “цөөнх” гэх) гэнэ<sup>23</sup>. Цааш нь Улсын Их Хурал дахь олон цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох бөгөөд үүнд бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүдийг оруулж тооцохгүй гэсэн байна.

<sup>19</sup> <https://sweden.se/society/the-swedish-system-of-government/> үз

<sup>20</sup> En.wikipedia.org- lastest hung parliament үз

<sup>21</sup> En.wikipedia.org- lastest hung parliament үз

<sup>22</sup> En.wikipedia.org- lastest hung parliament үз

<sup>23</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хууль УБ 2006 он үз

Үүнээс манайд хуулиар “олонх”, “цөөнх” гэсэн хоёр статус бий бөгөөд нэгэнт аль ч нам эвсэл 39-өөс дээш суудал аваагүй тохиолдолд парламент дахь бүхий л нам эвсэл “цөөнх”-ийн статусд орох юм. УИХ-ын тухай хуульд олонх цөөнхий тодорхойлоход орсон сонгуулийн дүнгээр гэсэн нь иргэд, сонгогчидын төр засагаа байгуулах үндсэн хуулийн зарчмын санаа байх нь гарцаагүй.

Нэгэнт 39 суудлаас дээш суудалтай нам эвсэлд Засгийн газраа байгуулах, бусад нөөцийн эрх боломж ирж байна гэж үзвэл өнөөдрийн манай улс төр дэх нэгэнт тогтсон ухамсарт энэхүү боломж, эрхийг 38-аас доош суудал бүхий нам эвсэлд шууд хамааруулан ойлгох хэвшил тогтол байх шиг. Иймд чухамхүү олонхгүй парламентын үед олонхтой парламент Засгийн газрыг байгуулахад өрнөхөөс өөр хууль эрхзүй, улс төрийн харилцаа өрнөх хэрэгцээ, зохицуулалтын шаардлага байж болохыг ч үгүйсгэхгүй. Энэ нь сонгуулийн суурь философи зарчим, Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйл дэх засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан энэ эрхээ эдлэх зарчим мөн үүнийг баталгаажуулсан УИХ-ын тухай хуулийн наймдугаар зүйлийн “...сонгуулийн дүнгээр...” гэсэн зарчим үг өгүүлбэртэй илүү нийтгэй юм.

Манайд олонхгүй парламент үүссэн тохиолдолд гарах гарцыг хуулийн хүрээнд Үндсэн хуулийн 33.1.2 дахь заалтаар хамгийн олон суудалтай нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх тухай заалтаар хардаг. Хэрэв “...хамгийн олон суудалтай нам, эвсэл зөвшилцэж чадаагүй бол Улсын Их Хуралд суудалтай бусад нам эвсэл зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдар дэвшүүлэх...” гэснээр нэг талаараа энэхүү олонхгүй парламентын тохиолдолд хамгийн олон суудалтай намаас бусад нам эвсэлд ч Засгийн газрыг эмхлэн байгуулах, бүтцэд орох боломж, мөн нөгөө талаараа хамгийн олон суудалтай намыг парламент дахь сөрөг хүчин болгож болох эрсдэлийг ч нээлттэй орхисон байх юм.

Үүнээс үзжээд хамгийн олон суудалтай нам эвсэл парламент дахь сөрөг хүчин болох улс төрийн үйл явц, зөвшилцэл байж болохыг үгүйсгэхгүй. Чухам хуулийн хүрээнд хэрхэн зөвшилцөх ажлыг эхлүүлэх чигийг Үндсэн хуулийн 33.1.2-д “хамгийн олон суудалтай нам”-д өгсөн хэрэг.

Олонхгүй парламентын засаглах, бодлого мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх эрх мэдэл, зөвшөөрлийг иргэд аль нэг намд олгоогүй тохиолдолд яах вэ? гэсэн үндсэн асуудал манайд олонход хамаарах улс төрийн эрх мэдэл, засаглалын нөөц боломжийг “олонх болоогүй цөөнхөд” шууд хамааруулж ойлгох явах уу гэсэн нэмэлт асуулт дагуулж байна.

Нэгэнт иргэд нийтээр даган мөрдөх хууль тогтоох эрхэм үүрэгтэй, иймийн учир нийгэм нийтийн төлөөллийг тусгах эрмэлзэл бүхий холимог сонгуулийн системээр байгуулагдсан парламентад ийнхүү нэг нам, улс төрийн хүчин дангаар олонх болохгүй байгаа нь манай парламентын өмнө олон намын систем бодитой орших, тэр тусмаа хоёроос доошгүй нам үйл ажиллагаа нь хүчтэй, харьцангуй олонхын дэмжлэг хүлээсэн байх хэмээх шалгуурыг багтаасан орчин үеийн парламентын хөгжилтэй хел нийлж чадах эсэх сорилт болж байна. Иймд парламентт ёс өөрт нь байж болох сөрөг талыг нь эрх зүйн аргаар зохицуулж зерэг талыг нь баяжуулах байдлаар ашиглах нь парламентт ёс бүрэн хэмжээгээр тогтсоны илэрхийлэл болох учиртай<sup>24</sup> юм.

Манайд “Олонхгүй парламент” –ын түүх тохиолыг хайвал 2004 он, 2012 оны сонгуулиар бий болсон байх бөгөөд харин “Эвслийн Засгийн газар”-ын тохиол 2004-2008 оны хооронд байгуулагдан ажиллаж байсан Ц.Элбэгдорж, М.Энхболдын Засгийн газар, мөн 2008 онд байгуулагдсан С.Баярын Засгийн газар, түүний бүтэц бүрэлдэхүүнээр үргэлжилсэн С.Батболдын Засгийн газар, 2012 оны сонгуулийн дараах Н.Алтанхуягийн тэргүүлсэн засгийн газар, одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж буй С.Сайханбилэгийн Засгийн газруудыг нэрлэж болно.

Ингээд парламентад олонх тодроогүйгээр эвссэн Засгийн газар болох 2004, 2012 оны сонгуулийн дараах Засгийн газруудыг тоймлөй. Энэ тохиолдолуудад хэрхэн гарц олж, асуудал нэхцэл байдлыг шийдвэрлэж байсан нь нэлээд сонирхолтой ч, нэгэнт тогтсон хэвшилгүй байгаа юм. Энэ нь ихэнхдээ тухайн үеийн улс төрийн нэхцэл байдал, улс төрийн нам, лидерүүд хоорондын харилцаанаас хамааралтай байж ирсэнтэй шууд холбоотой байж мэдэх юм.

2004 оны сонгуулийн дунд парламент дахь хоёр том нам аль аль ч олонх болж чадсангүй. Тэд энэ нэхцэл байдлыг хэнд нь ч засагийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх өгөөгүй, хэн хэн нь тэгш оролцох боломжтой гүж харсан байх үндэстэй байгаа юм. Ямартай ч 4 жилийн хугацааг адил тэнцүү жилээр хувааж УИХ-ын дарга, Ерөнхий сайдын суудалд тохирсон. “Эх орон Ардчилал” эвсэлээс Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газар үйл ажиллагаагаа явуулж нэг жил өнгөрсөн хугацаанд эвсэл задарч Ерөнхий сайд Ц.Элбэгдорж огцорсон юм. Ийнхүү 2005 оноос МАН-ын М.Энхболдын

<sup>24</sup> УИХ. ТГ “Дэлхийн улс орнуудын парламент” УБ 2010 он

Засгийн газар байгуулагдсан байдал. М.Энхболдын Засгийн газарт АН албан ёсоор хамтрахгүй гэсэн боловч тэдний зарим гишүүд кабинетад хамтарч ажиллаж байсан байна.

Энэ тохиолдолд олонх болоогүй улс төрийн намууд ирэх сонгууль хүртэлх хугацааг хоёр жилээр хувааж тохирсон нь нэг талаараа аль аль нь дангаар засаглах боломжгүй, негээ талдаа аль аль нь засаглаж болох хувилбар гэж харсан байж болох юм. Гэвч энэ шийдэлд өнөөдрийн пактаас ялгахад тэр үеийн парламентад хоёр гол намын аль нэгийг олонхын хэмжээнд хүргэх суудалтай гуравдагч нам хүчин байгаагүй, хэдийгээр байлгаж болох ч улс төрийн тогтвортой бааз байж чадахгүй байсан явдал нөлөөлсөн байж болох юм.

2012 оны сонгуулийн дүн, хууль тогтоох байгууллагын олонх суудлыг аль нэг нам эвсэлд өгсөнгүй. Ийнхүү Hung parliament манай улсад хоёрдахь удаагаа тохиолоо. Энэ удаад эрх баригч улс төрчид, хуульчид бусад судлаачид гарцыг олонх болох хэмжээнд намтай (нэг ч байж болно) зөвшилцөх хэмээн олжээ.

Энэ удаад дээрх гарц, шийдлүүдийг гаргахад баримталсан хуулийн зохицуулалтаа улс төрийн намууд, “тэдний” судлаач хуульчид олон янзаар тайлбарлан маргацааж байсныг дурдах нь илтгэлийн цаашидын ач холбогдолд холбоотой юм.

Өнөөгийн олонхгүй парламентын гарцыг өмнөх 2004 оны шийдвэртэй харьцуулахад мэдээж хэрэг өөр байна. Энэ нь олонх болох хэмжээнд хүргэх суудал бүхий улс төрийн хүчин байсантай холбоотой ч байж болох юм. Ямартай ч энэ удаагийн зөвшилшэл олон нийт, улс төрчид, судлаачдын дунд олон олон таамаг дагуулсан юм.

Одоо байгуулагдах Засгийн газрын бүтиэд сөрөг хүчин байсан МАН хамtran орох тухай улс төрийн нөхцөл, уйл байдлыг ажиглахад Олонхгүй парламентын зөвшилцөх талаар сонирхолтой ч, төдий сайнгүй дүр төрх ажиглагдаж байна.

Өмнөх огцорсон Засгийн газрын бүтиэд МАН-ыг багтаагаагүй нь хамгийн олон суудалтай АН-ын тайлбараар зөвшилцсөн болж, МАН-ын тайлбараар зөвшилцөөгүй болж байсан юм. Харин өнөөгийн шинэ Засгийн газрын бүтиэд МАН-ыг хамтруулах нь хамгийн олон суудалтай АН-ын хувьд олонхгүй парламентын тохиолдолд УХ-ийн 33.1.2. дахь заалтын дагуу “зөвшилцэн хамтрас” санаа гарч байна. Өнөөгийн Засгийн бүтиэд өмнөх Засгийн газрын үе дэх сөрөг хүчин байсан МАН-ыг хамтруулах нь цаашидын олонхгүй парламентад шинэ жишиг тогтоох явдал байж болно. Өөрөөр хэлбэл парламентад аль нэг нам олонх болоогүй тохиолдолд УИХ-д суудал бүхий намууд Засгийн газарт бүгд хамtran суудалтайгаа тэнцүү хэмжээний жин дарах жишиг байж болохоор байна. Чухам ийм жишиг тогтох нь орчин үеийн ардчилал, парламентат ёсны хэрэгиээ шаардлагад нийцэх алхам ч байж болох гэж судлаач бил харж байна.

Гэвч энэхүү тохиолдлыг нөлөө бүхий улс төрчид өөр өөрөөр харж байгааг дурдах нь зүйтэй юм.

Өнөөгийн Засагт хамтрас тухайд МАН-ын нөлөө бүхий гишүүн, УИХ-ын гишүүний ярианаас дээрх жишигийг цаашил үгүйсгэх хандлагатай гэмээр яриа гарч байна. Харин АН-ын томоохон улс төрч, УИХ-ын гишүүний хувьд цаашил дээрх жишигийг сайшаан дэмжих хандлага ч харагдаж байна. Ямартай ч олонхгүй парламентын үед өрнөх улс төрийн үйл явцыг тоймлон өгүүлэхэд ийм байгаа юм.

Дээрх улс төрийн үйл байдал, олонхгүй парламентын үе дэх шийдлүүдээс дүгнэхэд манайд олонхгүй парламентын нөхцөл дэх хууль эрхзүйн орчин, зохицуулалт хомс байгаа, иймд улс төрийн нам, гишүүд лидерүүдийн тохироо, нөлөөллийн түвшинд асуудал яригдаж шийдэгдэж байгаа нь илт байна.

Олонхгүй парламентын нөхцөлд гарах гарц, хууль эрхзүйн холбогдох гол зохицуулалт манайд УХ-ийн 33.1.2, УИХ-ын тухай хуулийн 8.1.8.2.8.3 мөн 9-р зүйлүүдээр тодорхойлогдох юм.

Парламентад олонх бүрэлдээгүй тохиолдолд гарах гарцын процесс талдаа, боломжийн дэлгэрэнгүй заалт нь “УИХ-д олонх суудал авсан нам эвсэлтээс нэр дэвшүүлсэн хүнийг, аль ч нам эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцэн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцэж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам эвсэл зөвшилцэн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар...<sup>25</sup>” гэсэн Ерөнхий лөгчийн бүрэн эрхэд хамаарах заалт байна. Ер нь энэ тохиолдолд дээрхээс өөр барьттай заалт үгүй байна.

Олонхгүй парламентыг нөхцөлүүлсэн сонгуулийн үр дүнт иргэд хэлцэн ярилцаж энэ байдалд хүргээгүй болохоор энэ яалт ч үгүй иргэдийн хүсэл зориг “хаан сонголт” мөн. Иргэдийн сонголтыг хууль тогтоох байгууллагад үнэн бодитой тусгах эрмэлзэлээр бид холимог сонгуулийн системийг

<sup>25</sup> Монгол улсын Үндсэн хууль 1992 он

нутагшуулж эхэлсэн. Гэтэл пропорциональ болон холимог системүүд парламентад нийгмийн тэгш төлөөллийг хангах, иймээс жижиг намуудад боломж олгох, улмаар эвслийн засгийн газар байгуулснаар бас гүйцэтгэх засаглал дахь төлөөллийг өргөтгөх сайн талтай нь үнэний хувьтай<sup>26</sup>.

2004, 2012 оны сонгуулиар олонх тодроогүй сонгуулийн өмнөх байдал, хүчний харьцааг үзвэл МАН/хуучин МАХН/-ын эсрэг хүчин, блокын хүч, нягтрал, эсвэл түүний/МАН-ын/ хүчний сарнилаас хамааралтай байна. Ерөнхийлбөл МАН-ын улс төрийн хүчний байдалтай аль аль тохиолдол нь ямар нэг байдаар холбогдсон байх юм. Тухайлбал 2004 оны сонгуульд 1990-ээд оноос хойш үүссэн улс төрийн нам хүчинүүд нэгдэж орсон бол 2012 оны сонгуульд МАН задарч МАХН туслаа бие даан сонгуульд орсноор нөхцөлдсөн байна. Үүнээс дүгнэхэд улс төрийн ууган хүчин МАН-ын улс төрийн нөлөө, дэмжлэг бааз нэгдсэн хүчтэй байж, шинэ хүчинүүдийн дэмжлэг бааз бүрэлдэж буй нь нөлөөлж байсан нь тодорхой байна.

Цөөнгүй сонгуулиар хоёр нам л Парламентад голлож ирсэн манай улс төрийн нөхцөл байдалд сонгуулийн систем холимог болсон эхний тохиолдолд аль ч нам олонх болоогүй нь улс төрийн намуудын төлөвшлийн нэг том шалгуур байсан гэж үзэж болох юм. Хэдийгээр сонгуулийн системтэй нь холбож болох ч зарим намуудын задрая, маргаан талцаал мөн Засгийн газарт хамтрах хийгээд түүнээс гарах гэх мэт тодорхойгүй, ойлгомжгүй улс төр эзэстээ улс төрийн намуудын төлөвшилд холбогдох эдгээр асуудлууд багагүй нөлөөлсөн болох нь гарцаагүй.

Сонгуулийн системийн холимог тогтолцоогоор сонгууль явуулахад хууль тогтоох байгууллагад олон намын төлөөлөл орж ирэх боломж өндөр байдаг. Энэ ч утгаараа нэг намын авах суудлын тоо парламентын нийт суудлын тэн хагасаас илүү байх боломжийг хумих буюу урвуу хамааралтай байдаг. Тиймдээ ч өмнө хэлсэнчлэн ийм системийн үед “Олонхгүй парламент” үүсэх магадлал өндөр байдгийг дурласан. Ингэхээр өнөөдрийн “Олонхгүй парламент”-ын нөхцөлдсөн шалтгааныг улс төрийн намуудын сонгуулийн өмнөх үйл байдал, сонгуулийн системтэй холбож үзэх нь зайлшгүй юм.

Ямартай ч ардчилсан улс төрийн системийн үед сонгууль юуны өмнө сонгогчийг төлөөлөн сонгогдогсдын засаглах эрх мэдлийг хязгаарлаж, алба хашсан хугацааны үйл ажиллагааных нь сонгуулийн нийт суудлын тэн хагасаас илүү байх боломжийг хумих буюу урвуу хамааралтай байдаг. Тиймдээ ч өмнө хэлсэнчлэн ийм системийн үед “Олонхгүй парламент” үүсэх магадлал өндөр дахин тэмдэглэхээ. Ийнхүү “Олонхгүй парламент” нь иргэдийн сонголт, оюун санааны зүгээс “Бүгдээрээ хэлэлцэвэл буруугүй” гэсэн сонголт байх нь гарцаагүй бөгөөд нөгөө талаараа улс төрийн тогтолцоонд улс төрийн зөвшлийг санал болгож байгаа хэрэг гэж үзэхэд хэтрүүлэггүй юм.

Сонгуулийн систем нэг үгээр иргэдийн үнэлэмж баримжааг төлөөллийн институтад суудал болгон хувиргадаг механизмыг юм<sup>27</sup>. Иймд сонгуулийн үр дүнд төрийн эрх барих дээд байгууллага болох хууль тогтоох байгууллагад олонх бий болоогүй нь иргэдийн үнэлэлт дүгнэлт гэдгийг дахин цохон тэмдэглээ. Энэ тохиолдолд иргэдийн сонголтыг хөдлөшгүй хүчин болгох шаардлага, санаа УИХ-ын тухай хуулийн олонх цөөнхийг тодорхойлох 8.1, 8.2 заалтуудад тусгагдсан “сонгуулийн дүнгээр” гэх үг мөн юм. Гагцхүү энэ үг үндсэн хууль дахь “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн өгүүлбэр ардчиллын мөн чанарыг тээж буй үг байж болох юм. Үүгээр зогсохгүй Улсын Их Хурал дахь олонх цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшишин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох заалт байгаа нь мөн л энэ үндсэн хуулийн зарчмыг дээдэлсэн хэрэг.

Ер нь судлаач эрдэмтэдийн бүтээл туурвилд Вестминстерийн загвар сайнаар дурдагдах цаг өнгөрсэн мэт. Аренд Лейпхарт “Ардчиллын хэв загвар” бүтээлдээ “Олонхийн ардчилал” нэрийн доор Вестминстер ардчилалд таатай хандаагүй юм<sup>28</sup>. Вестминстерийн гэгдэх эл системийг ихэнх ном зохиолд засгийн газар давамгайлсан хэмээн үздэг. Вестминстер загвар нь парламентын засаглалын үед эрх мэдэл хуваарилах онолыг хэрэглээгүй тохиолдол бөгөөд парламентад ялсан намаас засгийн газрыг байгуулдаг бодит үнэн байдаг ажээ. Ингэснээр парламентын олонх, засгийн газар, ялсан намын удирдлага түүний сонгогдог жишигээ гэгддэг Британийг “сонгуульт дарангуйлал”<sup>29</sup> хэмээн тэмдэглэсэн нь пактаас түүний сонгогдог жишигээ гэгддэг Британийг “сонгуульт дарангуйлал”<sup>30</sup> хэмээн тэмдэглэсэн нь байх юм.

<sup>26</sup> Э. Довчин “Харьцуулсан улс төр” УБ 2006 он 226 ху үз

<sup>27</sup> Э. Довчин “Харьцуулсануулстэр” 2006 он. Хуудас 221 үз

<sup>28</sup> Э. Довчин “Харьцуулсануулстэр” 2006 он. Хуудас 221 үз

<sup>29</sup> Аренд Лейпхарт “Ардчиллын хэв загвар”

<sup>30</sup> О. Машбат “Бонноос Вестминстерийнзүг” 2007 он.

<sup>31</sup> lord Hailsham 1978,127

Вестминстер загварын сүл талыг нөхөх боломжийг “Олонхгүй парламент” олгож байж болох юм. Хэрвээ бид 33.1.2 заалтыг зөв, хөдөлшгүйгээр тайлбарлаж хэрэглэж чадвал Вестминстериин төвлөрлийг сааруулах боломжтой байж болох юм. Үүнд зөв гэсэнд “бусад”, “зөвшилцөх” гэсэн үгсийг улс төрийн эрх ашиг, явцуу хүрээнд бус монгол үгийн утга агуулгаар бүрэн тайлбарлахыг ойлгож байна. Нэг намын төлөөлөл бүхий засгийн газар нь эрх мэдлийг олонхийн гарг төвлөрүүлэх байдалтай бол үүний эсрэгээр нөгөө талд эрх мэдлийг зөвшилцлийн үндсэн дээр өргөн хүрээнд хуваарилахөргөн намын төлөөлөлтэй засгийн газрыг байгуулах<sup>32</sup> боломж бидэнд байна.

Олонх цөөнхийн зөвшилд суурилах зөвшилцлийн загварын гол агуулга нь төрийн засаглалыг зөвхөн олонх биш, түүнийг оролцуулаад аль болох олон хүн хэрэгжүүлэх ёстой гэж үзэх явдал мөн. Тиймээс олонх зангаараа засаглах боломжийг аль болох хязгаарлах, цөөнхөд зарим талын эрх хэмжээ олгоход анхаардаг энэ загварын онцлог юм. Зөвшилцлийн загвар нь арчиллын төгс сонгодог утганд илүү нийцтэй аж<sup>33</sup>. Өнөөдөр Монголын нэргтэй судлаач эрдэмтэдийн дунд монгол төр ёсноо үе дамжин уламжлагдаж ирсэн эв нэгдэл, үнэнч туштай чанарыг дээдэлсэн зөвшилийн арчиллын хэлбэрүүдийг орчин үеийн либерал арчиллын нийтлэг зарчмуудтай зохицтой уялдуулах боломжийг судлан боловсруулах шаардлага манай арчиллын хөгжлийн цаашлын нэг чухал зорилт байж болох талтай<sup>34</sup> хэмээн нэгэнт бичиж эхэлжээ.

УИХ-ын тухай хуулийн 8.1.8.2.8.3 мөн Үндсэн хуулийн 33.1.2 заалтуудыг үндэс болгон туйлбартай баримталж үүссэн нөхцөл байдалд гарцыг эрэлхийлбэл сайн засаглал, үр өгөөжтэй бодлого тогтвортой байх үндэстэй юм. Ямартай ч төрийн дээд эрх ард түмний мэдэлд байх тухай Үндсэн хуулийн зарчмыг дэлгэрүүлж баталгаажуулсан төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт хангалтгүй<sup>35</sup> гэсэн тэргүүлэх эрдэмтэдийн санал дүгнэлт бий бөгөөд магадгүй энэ хэрэгцээ шаардлагад “Олонхгүй парламент”-ын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал эн тэргүүний ач холбогдолтой гэж үзэж байна. Ер нь цаашид улс төрийн бодлогын хүрээнд хариушлага, ил тод байдал иргэдийн оролцоог дэмжих, төвлөрлийг сааруулах зэрэг алхмуудыг хэрэгжүүлэх замаар сайн засаглал, арчиллын институтыг бэхжүүлэх нь чухал байгаа юм<sup>36</sup>.

## ДҮГНЭЛТ

Вестминстер загварын парламентын засаглалтай улс оронд хууль тогтоох байгууллагад олонх бүрдэхгүй байх үзэгдэл байдаг байна. Чухам гарах гарцыг улс орнуудад ялимгүй олонхын засгийн газар байгуулах хэмжээнд харж зохицуулж ирсэн туршлага цөөнгүй байна. Цаашид ч энэ байдал адил төрийн засаглалтай улс оронд хуулбарлагдан зохицуулагдах төлөв байдал харагдаж байна. Чухам манай орны хувьд арчиллагд шилжсэнээр 20 гаруй жил туулсан, энэ хугацаанд хоёр дахь удаагаа Олонхгүй парламент үүсээд байгаа юм. Өмнө өгүүлсэнчлэн бусад тесөөтэй улс орны жишигийг даган хуулбарлах, тайлбарлах хандлага манай улс төрчид, судлаачдын дунд элбэг ажиглагдаж байна. Энд манай орны хувьд юуны өмнө хууль эрхзүйг зөв ашиглан дадахуй толевшил, иргэд сонгогчдын эрх ашгийн төлөөлөл, улмаар улс төрийн намуудын төлөөллийг ханган тогтвортой сайн засаглалыг дэмжин тогтоох шаардлагын үүднээс дээрх жишигээс өөр зохицуулалт, онцлогтой хувилбарыг бий болгох хэрэгцээ байж болох юм. Энэ нь төрийн систем, улс төрийн намын төлөвшил, соёл бүрдэж эхэлж буй манайд ч харгалzan үзэхэд ч дэмий хоосон биш юм. Эцэст нь дүгнэн хэлэхэд Вестминстер загвар дахь шүүмжлэлд өртөж ирсэн сүл талуудыг нөхөх боломж болгон ашиглахад олонхгүй парламент таатай орчин байж болох юм.

<sup>32</sup> Аренд Лийпхарт “Арчиллын хэв загвар” 113 үз

<sup>33</sup> Г.Чулдунбаатар “ХХ-ХХI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншилийн өөрчлөлт” УБ 2008 он 76 ху үз

<sup>34</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын нийгмийн өөрчлөлт” УБ 2013 он 246 ху үз

<sup>35</sup> МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын нийтмийн өөрчлөлт” УБ 2013 он 243 ху үз

<sup>36</sup> МУТСНХолбоо “Арчилал: Асуудал, Эрэл, Шийдвэр” УБ 2012 он 40 ху үз

## НОМ ЗҮЙ

1. МУ-ЫН Үндсэн хууль УБ 1992 он
2. МУ-ЫН Засгийн газрын тухай хууль УБ 1993 он
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль УБ 2006 он
4. МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын ардчиллын төлөвшил” УБ 2011 он
5. МУШУА-ФСЭЗ хүрээлэн “Монголын нийгмийн өөрчлөлт” УБ 2013 он
6. Мартин Слани “Улс төрийн удиртгал” УБ 2007 он
7. Аренд Лийпхарт “Ардчиллын хэв загвар”
8. Роберт Даль “Ардчиллын тухай”
9. Ё.Довчин “Харьцуулсан улс төр” УБ 2006 он.
10. О. Машбат “Бонноос Вестминстерийн зүг” УБ 2007 он
11. МУТСНХолбоо “Ардчилал: Асуудал, Эрэл, Шийдэл” УБ 2012 он
12. Г. Чулуунбаатар “ХХ-XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт” УБ 2008 он
13. Удо Баркманн “Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд” ном 2012 он
14. МУИС, Улс төр судлалын тэнхим “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2010 он
15. Ж. Тортогох “Парламент судлалын гарын авлага” УБ 2010 он
16. УИХ-ЫН Тамгын газар “Дэлхийн улс орнуудын парламент” УБ 2010 он
17. Улс Төрийн Боловсролын Академи “УТБА-ийн лекцийн эмхэтгэл” II УБ 2004 он
18. En.wikipedia.org- lastest hung parliament
19. <http://www.instituteforgovernment.org.uk/>
20. Hung parliament – [http://en.wikipedia.org/wiki/Hung\\_parliament](http://en.wikipedia.org/wiki/Hung_parliament)
21. <https://sweden.se/society/the-swedish-system-of-government/>
22. <http://www.instituteforgovernment.org.uk/publications/programme-effective>
23. <http://www.instituteforgovernment.org.uk/our-work/parliament-and-political-process/making-coalition-government-work#sthash.sEGt2HAO.dpuf>
24. <http://www.instituteforgovernment.org.uk/our-work/parliament-and-political-process/government-renewal>
25. [http://en.wikipedia.org/wiki/Minority\\_governments\\_in\\_Canada](http://en.wikipedia.org/wiki/Minority_governments_in_Canada)  
[http://en.wikipedia.org/wiki/Minority\\_government](http://en.wikipedia.org/wiki/Minority_government)